

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшин тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 17.30 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: ndeg.hr@ndaatgal.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 99188866

Шинэ ажлын байрны жагсаалт:

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар	Тэтгэврийн даатгалын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	1	Гүйцэтгэх	T3-7	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	Эдийн засаг /0311/; Нягтлан бодох бүртгэл, татвар /0411/; Санхүү, банк, даатгал /0412/; Менежмент ба удирдахуй /0413/; Эрх зүйч /0421/.	-	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
2		Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн нарийн бичгийн дарга	1	Гүйцэтгэх	T3-4	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	Анагаах ухаан /091/	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх;	-Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-өөс доошгүй жил ажилласан байх; -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 3-өөс доошгүй жил ажилласан байх.